



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 1/75

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.16 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ашиглагдаж буй дулаан дамжуулах төв-8 нь зураг, төсвийн дагуу хэдэн төгрөгөөр хийгдсэн, 74 сая төгрөгт багтаан орон нутгийн өмчид худалдан авахад боломжтой эсэхэд хянан баталгаажуулалт хийж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баярсүх - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

Гишүүд:

Ш.Мөнхзаяа - Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч

Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Л.Гэрэлмаа - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

Р.Янжмаа - Ховд аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн

Т.Бямбатөмөр - "Ховд дулаан станц" төрийн өмчит хувьцаат компаний ерөнхий инженер

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:
Д.Эрдэнэбат

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын мэргэжилтэн

2. Үүссэн нөхцөл байдалд дүгнэлт гарган 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн дотор багтаан танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ДҮГЭРЖАВ

